



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1 “Эрдэнэс Алт Ресурс” ХХК /цаашид “ЭАР” ХХК гэх/-ийн ажлын байрны эрсдэлийг тодорхойлох, судлан шинжлэх, үнэлэх, засаж залруулах, мэдээлэх болон түүнд байнгын хяналт хийх нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлийн менежментийн тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд холбогдох харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.2 “Энэхүү журам нь “ЭАР” ХХК-ийн уурхайн болон уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй гэрээт болон туслан гүйцэтгэгч компани, тэдгээрийн ажилтанд нэгэн адил хамаарна.
- 1.3 Энэхүү журамд тусгагдаагүй аливаа харилцааг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, ажлын горим, зааврын дагуу зохицуулна.

Хоёр. Эрсдэл

- 2.1 “ЭАР” ХХК нь компанийн дотоод, гадаад хүчин зүйлийн үр нөлөөг тодорхойлох эрсдэлээс хамгаалахтай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авна.
- 2.2 Ажлын байранд хүний биед бэртэл, гэмтэл учруулах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх, эд хөрөнгийн хохирол үүсгэх аюул бүхий болзошгүй нөхцөлийн эрсдэлийг тодорхойлно.
- 2.3 Эрсдэлийг тодорхойлох үйл явцад илэрсэн аливаа хүний биед бэртэл, гэмтэл учруулах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх, эд хөрөнгийн хохирол үүсгэх аюул бүхий болзошгүй нөхцөл байдлын хор хохирлын магадлал, үр дагавраар эрсдэлийн үнэлгээ хийнэ.
- 2.4.Энэ журмын 2.3-ийг үндэслэн эрсдэлийн хяналтыг тогтмол хийж, ажлын байранд хүний биед бэртэл, гэмтэл учруулах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх, эд хөрөнгийн хохирол үүсгэх магадлалыг арилгах, бууруулах арга хэмжээг авна.
- 2.5 “ЭАР” ХХК-ийн эрсдэлийг хянах бүхий үйл ажиллагааг зохицуулах эрсдэлийн менежментийг тухайн бүр хийж байна.

Гурав. Аюулыг тодорхойлох

- 3.1 Ажлын байранд үүсэж болох аюул, эрсдэл үүсэхээс сэргийлэх ба энэ нь дор дурдсан болон бусад эх үүсвэрээс үүсэх магадлалтай.
- 3.1.1. Ажлын байрны загвар, зохион байгуулалт муугаас;
 - 3.1.2. Аюул, эрсдэл бүхий ажил үүрэг гүйцэтгэхээс;
 - 3.1.3. Бүрэн бус машин механизмыг үйл ажиллагаанд нэвтрүүлэхээс;
 - 3.1.4. Машин механизм суурилуулах, ашиглалтад оруулах, ашиглах, үзлэг хийх, үйлчилгээ хийх, засварлах зэрэг ажлыг буруу хийхээс;
 - 3.1.5. Машин механизм, багаж, тоног төхөөрөмжид өөрчлөлт хийснээс;
 - 3.1.6. Аюултай бодис, эрсдэл бүхий үйл ажиллагаа эсхүл орчны нөлөөллөөс зэрэг болно,
- 3.2. Эрсдэлийг тодорхойлох үйл явц нь дээр дурдсан болон бусад бүх эх үүсвэрээс гаралтай аюултай нөхцөл байдлыг олж тодорхойлоход чиглэгдэн.
- 3.3. Хэлтэс нэгжийн удирдлага нь ажлын байранд аливаа шинэ тоног төхөөрөмж, шинэ бодис, үйл ажиллагаа болон ажлын шинэ туршлага нэвтрүүлэхийн өмнө үүнтэй

холбоотой гэмтэх эсхүл өвчлөх эрсдэл байгаа эсэхийг урьдчилан тогтоох үүрэгтэй.

3.4. Байгууллагад эрүүл ахуй, аюулгүй ажиллагаанд эрсдэл учруулах магадлал бүхий шинэ үйл ажиллагаа, туршлага, тоног төхөөрөмж, бодис болон тэдгээрийн эрсдэлийг урьдчилан тодорхойлсон байна

3.5. Ажилчид өөрсдийн ажлын байрныхаа болзошгүй аюул эрсдэлийг олж илрүүлэх, түүнийг мэдээлэх, арилгах, бууруулах тухайн аюулаас өөрийгөө болон хамтран ажиллагсдаа бүрэн тусгаарлах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

3.6. Ажилчид өдөр тутмын ажлаас бусад ажил үүрэг, түүн дотор анх удаа хийгдэж буй болон эрсдэл өндөртэй ажлуудыг гүйцэтгэж эхлэхийн өмнө эрсдэлийн үнэлгээ, ажлын аюулын шинжилгээ Эрсдэлийн үнэлгээний /Хавсралт 1/ маягт ашиглан үнэлгээ хийх үүрэгтэй.

3.7. Аюулыг илрүүлж буй ажилтан нь шаардлагатай сургалтад хамрагдаж, дадлагажсан байх ба ахлах ажилтан болон ХАБ-ын мэргэжилтнээс туслалцаа авах боломжтой.

3.8. Тоног төхөөрөмжтэй харьцахад үүсэж болох механик аюулын жишээ

- Татагдан орох болзошгүй хэсэг
- Хайчлах хэсэг
- Дарагдаж, няцлагдах хэсэг
- Таслах, зүсэх хэсэг
- Орооцолдох хэсэг
- Хурц, огцом хэсэг
- Хавирах, шүргэх хэсэг
- Үсэрч болох хэсэг
- Гэмтэл учруулж болох цухуйсан, ил гарсан хэсэг гэх мэт
- Тоног төхөөрөмжтэй харьцахад үүсэж болох механик бус аюулын жишээ
- Гар ажиллагааны болон эргономикийн¹ аюул
- Цахилгаанд цохиулах болон түлэгдэх аюул
- Химийн түлэгдэл, хордох, шатамхай бодисын аюул
- Чимээ шуугиан
- Чичиргээ, доргилт
- Цацраг идэвхжил
- Манан, тоос шороо, утаа
- Багтрах
- Булагдах
- Биологийн аюул, вирусийн
- Халтирах, бүдрэх, унах аюул
- Дээрээс юм унах
- Өндөр даралттай шингэн
- Хэт халуун биетэй ажиллах
- Хэт халуун эсхүл хэт хүйтэн нөхцөлд ажиллах
- Хавчигдах эсхүл биеийн аль нэг хэсгийг хавчуулах
- Нуралт гулсалт болон геотехникийн аюултай бүсэд ажиллах гэх мэт байна

3.9. ЭАР ХХК нь дараах онцлог эрсдэл бүхий ажлуудад заавал Эрсдэлийн үнэлгээний маягыг бөглөж эрсдэлээ үнэлсний дараа ажлаа эхлүүлэхийг шаардана.

- Өндөрт болон хязгаарлагдмал орчинд ажиллах;
- Аюултай бодис, бараатай харьцан ажиллах;
- Кранаар ачаа өргөх, буулгах;
- Их хэмжээний шаталт, уугилтыг унтраах
- Өмнө нь огт хийгдэж байгаагүй ажлыг мөн оролцуулна.

3.10. Аюулыг тодорхойлох явц, Эрсдэлийн үнэлгээ-г дараах тохиолдолд давтан

гүйцэтгэнэ.

- Тоног төхөөрөмжийн аливаа шинэчлэлт болон ашиглах чиглэл өөрчлөгдөх эсхүл уг төхөөрөмжтэй холбоотой ажлын систем солигдохын өмнө.
- Ажлын байранд ашиглагдаж буй тоног төхөөрөмж эсхүл гар ажиллагаа оролцсон ажлын систем өөрчлөгдөх болон ажил явагдаж байгаа газарт өөрчлөлт хийхийн өмнө.
- Машин механизмыг үндсэн зориулалтаас нь өөр зорилгоор ашиглахын өмнө.
- Объектыг зориулалтаас нь өөр зорилгоор ашиглах тохиолдолд гар ажиллагаа гүйцэтгэх ажилтан аюул, эрсдэлтэй ажил эхлэхийн өмнө.
- Хэрэв аюул эрсдэлийн талаар шинэ эсхүл нэмэлт мэдээлэл гарч ирвэл.
- Тухайн ажлыг гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орвол Эрсдэлийн үнэлгээг давтан хийж эрсдэлийг дахин үнэлнэ.

Дөрөв. Эрсдэлийн үнэлгээ

4.1. Ажилтан аюул эрсдэлийг тодорхойлсон даруйдаа холбогдох ажилчидтай зөвлөж эрсдэлийн үнэлгээ хийх үүрэгтэй. Эрсдэлийн үнэлгээг байгууллагын эрсдэлийн үнэлгээний болон Эрсдэлийн үнэлгээ-ний маягтаар хийж гүйцэтгэнэ.

4.2. Тухайн ажлыг хариуцсан ахлах ажилтан нь шаардлагатай гэж үзсэн алба хэлтсийн мэргэжилтнүүдийг эрсдэлийн үнэлгээний багт татан оролцуулан хамтран ажиллана.

4.3. Эрсдэлийн үнэлгээгээр аюулыг тогтоох үед боломжит бүх аюултай нөхцөл байдал бүртэй холбоотой гэмтэж, бэртэх, өвчин эмгэг тусах магадлал байгаа эсэхийг тодорхойлох бөгөөд дараах нөхцөлүүдийг харгалзан үзнэ.

- Ажилтан боломжит бүх ажилбар тус бүрээр (жишээ нь: тоног төхөөрөмжийг суурилуулах, ашиглалтад оруулах, угсрах, ажиллуулах, үзлэг хийх, засварлах, үйлчилгээ хийх болон цэвэрлэх) аюулд өртөх магадлалтай эсэх?

- Уг аюулд өртөж болзошгүй хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг газар дээр нь хамгаалах ямар арга хэмжээ байгаа, авсан арга хэмжээ хэр тохиромжтой вэ?

4.4. Хэрэв тухайн нөхцөл байдалд хэн нэг нь өртөх магадлал ажилбар тус бүрд аюулгүй гэж үзвэл нэмэлт арга хэмжээ шаардлагагүй.

4.5. Эрсдэлийн үнэлгээг дараах алхмуудаар хийнэ.

- Алхам-1. Эрсдэлийн түвшнийг тогтоохдоо илэрсэн аюул тохиолдвол гарч болох үр дагавар буюу хохирлыг тодорхойлно.
- Алхам-2. Аюул тохиолдох магадлал буюу давтамжийг тодорхойлно.
- Алхам-3. Үр дагавар болон магадлалыг тодорхойлсноор эрсдэлийн матриц дээр эрсдэлийн зэрэглэл тогтооно. Тухайн матриц дээрх хоёр баганын огтлолцол нь тооцоолсон эрсдэлийн оноо бөгөөд матрицын ард байх жижиг хүснэгтээс эрсдэл өндөр, дунд эсхүл бага аль түвшинд байгаа нь харагдана.

4.6. "Оноо" нь дор дурдсан байдлаар эрсдэлийн түвшнийг тодорхойлно.

- 1-8 Эрсдэлийн бага түвшин
- 9-15 Эрсдэлийн дунд түвшин
- 16-20 Эрсдэлийн их түвшин
- 21-25 Эрсдэлийн түвшин маш их

4.7. Ажилтан Эрсдэлийн үнэлгээ хийж эрсдэлийн оноо нь дунд түвшнээс өндөр байх тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэж эхлэхийн өмнө ахлах ажилтнаас зөвшөөрөл авах үүрэгтэй.

Санамж: Тодорхой нэг нөхцөл байдалд хэн нэгэн аюулд өртөх магадлалтай байвал тухайн үед хэрэгжүүлж буй хяналтын арга хэмжээг хангалттай эсэхийг дахин шалгана.

4.8. Тухайн ажилд гэрээт компанийн техник хэрэгсэл болон ажилтан оролцох

тохиолдолд уг ажилтныг Эрсдэлийн үнэлгээ хийхэд заавал оролцуулна.

4.9. Осол гараагүй гэсэн энгийн шалтгаанаар тухайн үед хэрэгжүүлж буй хяналтын арга хэмжээнүүдийг хангалттай гэж үзэхгүй. Ялангуяа тухайн хяналтын арга хэмжээнүүд нь зөвхөн захиргааны (сургалт, аюулгүй ажиллагааны журам, аюулгүйн тэмдэг, хяналт гэх мэт) болон нэг бүрийн хамгаалах хэрэгслээр (хамгаалалтын бээлий, нүдний хамгаалалтын шил гэх мэт) хязгаарлагдаж байгаа тохиолдолд энэ заавал дахин шалгаж үзнэ.

4.10. Захиргааны болон НБХХ-ийн хяналт нь хүний зөв үйлдэл, зөв арга барилаар ажиллах зан үйлд голлон тулгуурладаг тул тухайн ажилтан буруу үйлдэл хийсэн тохиолдолд энэхүү хоёр хяналтын арга хэрэгсэл нь ажилтны буруу үйлдлийг зогсоох арга хэрэгсэл болж чадахгүй.

Тав. Эрсдэлийн хяналт

5.1. Эрсдэлийн үнэлгээ хийсний дараа уг эрсдэлд хяналт тогтоох шаардлагатай бол “Хяналтын шатлал”-аас тухайн нөхцөлд тохирсон арга хэмжээг сонгон авч хэрэгжүүлнэ.

5.2. Тухайн үед хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалтгүй болох нь тогтоогдсон эсхүл тухайн нөхцөлөөс шалтгаалан гэмтэх, өвчлөх магадлал нь буурахгүй байгаа тохиолдолд “Хяналтын шатлал”-аас дараагийн

5.3. Хяналтын шатлал

- Аюулыг бүрэн устгах
- Аюулыг бууруулах
- Ажилтныг аюул эрсдэлээс тусгаарлах

5.4. Эрсдэлийн хяналтын үндсэн шаардлага

5.4.1. Эрсдэлийн хяналт нь хэрэгжүүлэх бодит боломжтой өөрөөр хэлбэл дараах зүйлсийг бүрэн тооцсон байна.

- Аюул тохиолдох магадлал (хүнд гэм хор учрах магадлал);
- Аюул тохиолдоход учрах хор уршгийн зэрэг (гэмтэл, хохирлын хэмжээ);
- Аюул эрсдэлийг бууруулах арга замын талаар тухайн ажилтан мэдэж байгаа эсэх эсхүл мэдвэл зохих мэдлэг мэдээлэл;
- Аюул эрсдэлийг арилгах эсхүл бууруулах арга нь хэрэгжүүлэхэд тохиромжтой бөгөөд шаардлагатай тоног төхөөрөмж байгаа эсэх;
- Зардлын хувьд хэрэгжүүлэх боломжтой эсэх гэх мэт.

5.4.2. Эрсдэлийн хяналтын үйл ажиллагааг тухайн ажилд оролцох ажилтнуудтай хэлэлцэж, ойлголцсоны үндсэн дээр эрсдэлийн үнэлгээний болон Эрсдэлийн үнэлгээний маягтаар хийж гүйцэтгэсэн байна.

5.4.3. Илрүүлсэн аюул эрсдэлд хяналт тогтоохдоо хамгийн үр нөлөө сайтай аргыг эхний ээлжид сонгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл аюулыг арилгах, орлуулах, инженерчлэл, захиргааны болон НБХХ-ийн арга гэсэн дарааллаар сонголтоо хийнэ гэсэн үг юм. Аюулыг арилгахаар сонгосон арга нь аливаа нөөцийн хувьд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй бол эрсдэлийг бууруулах дараагийн үр нөлөөтэй арга хэмжээг олж тодорхойлон түүнийгээ хэрэгжүүлнэ.

5.4.4. Аюулаас үүсэн гарч болох гэмтэл, өвчлөлийн зэргийг тооцоход хор уршгийн хэмжээ өндөр байх тохиолдолд (нас барах, хүнд гэмтэл г.м) эрсдэлийг бууруулах аргуудаас хүний үйлдлээс бага шалтгаалах арга хэмжээнээс (устгах, инженерчлэлийн хяналт, тусгаарлалт г.м) сонгох шаардлагатай.

Санамж; Эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд нөлөөлөх эрсдэл байгаа бол уг эрсдэлийг арилгах эсхүл дорвитой бууруулах арга хэмжээ авах хүртэл тэрхүү үйл ажиллагааг зогсоож, бүрэн зогссон эсэхийг шалгаж магадлан.

5.4.5. Эрсдэлийн хяналтын тохирох арга сонгож хэрэгжүүлэх шийдвэр гарсан даруйд түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг холбогдох хэлтсийн ахлах ажилтан болон менежер

нь зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулах хэрэгтэй. Төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгасан байна.

- Авах шаардлагатай арга хэмжээ, ажилбарууд
 - Ажлуудыг хийх цагийн хуваарь
 - Арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх ахлах ажилтнууд
- 5.5. Эрсдэлийн хяналтад тавих ахлах ажилтны үүрэг
- Ахлах ажилтан нь тухайн арга хэмжээнд оролцож буй ажилтнуудыг удирдан чиглүүлж ажиллана.
 - Ахлах ажилтан нь боловсруулсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэх, явцын хяналт тавьж байх үүрэг хүлээнэ. Ажлын байрны үзлэгийг тогтмол хийх замаар уг арга хэмжээний хэрэгжилтийг хангана.

Зургаа. Ажлын аюулын шинжилгээ

6.1. Урт удаан хугацаанд гүйцэтгэж ирсэн ажлын хувьд уг ажлыг хийх хамгийн зөв, аюулгүй замыг олох нь чухал байдаг, тодорхой хугацааны давтамжтайгаар тухайн ажлын байранд үзлэг, Эрсдэлийн үнэлгээ хийнэ.

6.2. Өдөр тутам хийдэггүй ажилд тухайн ажлыг эхлэхээс өмнө Эрсдэлийн үнэлгээ хийж уг ажлын байрны эрсдэлийг үнэлнэ.

6.3. Компанийн ажилтан бүр Эрсдэлийн үнэлгээ-ний маягтыг ашиглаж өөрийн ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдалд үр дүнтэй шинжилгээ хийх дараах таван алхмыг мөрдөнө.

- “Ажлын үе шатыг тогтоох” гэдэг нь тухайн ажлыг гүйцэтгэх бүх ажилтныг цуглуулж, “Эрсдэлийн үнэлгээ”-ний хуудсыг ашиглан уг ажлыг явц, үе шат болгоноор задалж бичнэ. Жишээ нь: Кранаар ачааг өргөөд хажуу тийш нь зөөж буулгах ажлын тухайд краныг байрлуулахаас эхлээд ачааг оосорлох, өргөх, зөөх, буулгах зэрэг үе шат бүрийг задлан бичнэ.

- “Үе шат бүрийн аюулыг тодорхойлох” гэдэг нь тухайн ажлын үе шатны ямар хэсэг нь уг ажил үүргийг гүйцэтгэж байгаа эсхүл ойр орчинд нь байгаа ажилтанд аюул учруулж болзошгүй болохыг тогтоож бичнэ.

- “Хяналтын арга хэмжээг сонгох” тодорхойлсон аюул бүртээ “Эрсдэлийн үнэлгээний матриц”-ийг ашиглан, тухайн ажилд оролцож байгаа ажилтан бүрд учирч болзошгүй Эрсдэлийн түвшнийг үнэлнэ. Дараа нь тэдгээр эрсдэлийг арилгах эсхүл бууруулахад шаардлагатай хяналтын арга хэмжээнүүдээ сонгож жагсаан бичнэ.

- “Хариуцах этгээдийг тогтоох” хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн этгээдийг тогтоож тэмдэглэнэ.

- “Хяналт тавих” ажлын явц нь Эрсдэлийн үнэлгээ-д тодорхойлогдсоны дагуу явагдаж байгаа эсэхийг газар дээр нь хянах шаардлагатай. Өмнө тодорхойлсон үйл ажиллагаа болон хүн хүч, тоног төхөөрөмж өөрчлөгдөх бүрд эсхүл тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлгээг дахин хянаж байх нь шаардлагатай.

Долоо. Бүртгэл, тэмдэглэл хөтлөх

7.1. Холбогдох баримт бичиг, бүртгэлийг баримтжуулан хадгалж, ашиглах нь эрүүл аюулгүй ажлын орчин бүрдүүлэх, хууль стандартыг даган мөрдөж байгаагаа нотлон харуулахад тусална. Ажилчид “Эрсдэлийн үнэлгээ”-ний маягтыг бөглөхөд хамтран оролцох, түүнийг ашиглах үүрэгтэй бөгөөд уг бөглөсөн маягтыг ХАБЭА-н хэсэгт өгч хянуулан уурхайн “Эрсдэлийн үнэлгээ”-ний хавтсанд хавсаргана.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

№:

Ил уурхайн ханын нурангид хийгдсэн
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

АЛХАМ 1 – АГУУЛГА ТОДОРХОЙЛОХ

Эрсдэлийн үнэлгээний зорилго, хамрах хүрээг бичих.

- Ил уурхайн түвшинд хананы нуранги үүссэн ба үүсэж болох аюулыг бууруулах, яаралтай арилгах.
- /Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үүссэн эвдрэл, нэмэлтээр байршуулах шаардлага үүссэн/-ийг яаралтай арга хэмжээг авах.

Эрсдэлийн үнэлгээний үйл ажиллагааны гадаад орчныг тодорхойлох.

- Агаарын температурын -40°C $+40^{\circ}$ хооронд хэлбэлзэнэ.
- Ил уурхайн догол, мөргөцөгт үүссэн усны шүүрэлт нь цаашид уурхайн гадаргууг эвдрэлд оруулж болзошгүй байдалтай.

Эрсдэлийн үнэлгээнд орсон ноцтой эрсдэлүүд.

- Цаг агаарын хүчин зүйлд өртөх. /халуун хүйтэн/
- Нуранги, бутармал чулуулгууд унах.
- Нуралт үүссэнээс болж машин техник болон, хүн даруулах.
- Уурхайн гүний түвшин ахих ажлын явцад хүндрэл үүсэх, цаашид үргэлжлүүлэх боломжгүйд хүрэх эрсдэл үүснэ.
- Нурсан шороог чулуулгуудыг нүүн шилжүүлэх төлөвлөгөөт бус ажил нэмэгдэнэ.

Тоног төхөөрөмжийн мэдээллийг багтааж болно.

НЭР	АЛБАН ТУШААЛ	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮҮРЭГ (ЗОХИЦУУЛАГЧ/ ОРОЛЦОГЧ)	КОМПАНИ	ЗӨВШИЛЦӨЛ ТИЙМ/ ҮГҮЙ	ГАРЫН ҮСЭГ
	СУБУ-ийн АХЛАХ ИНЖЕНЕР	Зохицуулагч	"Эрдэнэс алт рэсурс" ХХК		
	Төлөвлөлт ашиглалтын инженер	Зохицуулагч	"Эрдэнэс алт рэсурс" ХХК		
	Маркшейдэр	Зохицуулагч	"Эрдэнэс алт рэсурс" ХХК		
	ХАБ, ГГАХ-н инженер	Зохицуулагч	"Эрдэнэс алт рэсурс" ХХК		
	Ашиглалтын инженер	Оролцогч			
	Уулын мастер	Оролцогч			
	Маркшейдэр	Оролцогч			
	ХАБЭА-н инженер	Оролцогч			
	Экскаватор оператор	Оролцогч			
	Экскаватор оператор	Оролцогч			

ҮР ДАГАВАР				
Үнэлгээ	Эрүүл мэнд	Байгаль орчин	Нэр хүнд	Эд хөрөнгө
Маш бага	Ямарваа гэмтэл, өвчлөл үүсэх боломжгүй, эсвэл анхны тусламж шаардлагагүй тохиолдол, осолд дөхсөн тохиолдол	Хэмжиж үл болохуйц нөлөөлөл, байгаль орчинд маш бага нөлөөлсөн	Орон нутгийн иргэдийн гомдол санал олон нийтийн анхааралд хүрээгүй / хязгаарлагдсан	25,000\$ хүртэл
Бага	Анхны тусламж шаардлагатай хөнгөн гэмтэл	Түр зуурын, богино хугацааны бага байгаль хэмжээний байгаль орчны нөлөөлөл	Компанийн тухай ноцтой бус гомдол санал гарах, мэдээллийн хэрэгслээр бага хэмжээнд цацагдах	25,000\$- 250,000\$
Дунд зэрэг	Эмнэлгийн тусламж / үйлчилгээ, эсвэл өөр ажилд шилжүүлэх шаардлагатай байнгын нөлөөгүй өвчин / гэмтэл	Тодорхой /дунд/ хэмжээний, түр зуурын, болон байнгын багавтар нөлөөлөл	Орон нутгийн иргэдээс гарсан гомдол санал, мэдээллийн хэрэгслээр тодорхой хэмжээнд цацагдах	250,000\$ - 2,000,000
Их	Хүн Цагийн Алдагдалтай гэмтэл / өвчлөл, эсвэл эргэн сэргээгдэх боломжтой (1-р зэрэг) хөдөлмөрийн чадвараа бүрэн алдалт	Байгаль орчны ноцтой хохирол	Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн нэр хүндэд нөлөөлөх хэвлэл мэдээллийн болон, олон нийтийн анхаарал татсан ноцтой мэдээлэл	2,000,000\$ - 20,000,000\$
Маш их	Эргэн сэргээгдэх боломжгүй (1-р зэрэг) хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гэмтэл, Амь насаа алдах (1 ба хэд хэдэн)	Өргөн тархсан, ноцтой сөрөг нөлөөлөл	“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн нэр хүндэд ноцтойгоор нөлөөлөх хэвлэл мэдээллийн болон олон нийтийн эсэргүүцэл	20,000,000\$ түүнээс дээш

ҮР ДАГАВАР					
	Маш бага	Бага	Дунд зэрэг	Их	Маш их
Магадлал	Өндөр магадлалтай	8	20	23	25
	Магадлалтай	7	18	21	24
	Боломжтой	4	13	19	22
	Магадлал багатай	3	10	16	17
	Магадлал маш багатай	1	6	12	14

МАГАДЛАЛ			
Зэрэглэл	Боломж	Тайлбар	Магадлал
A	Өндөр магадлалтай	Ажлын байранд, эсвэл компанийн хэмжээнд хэд хэдэн удаа гарч байсан бөгөөд энэ талбар дээр хэзээ нэг цагт гарах магадлал маш өндөр, өөр компаниудад олон удаа гарч байсан	>70%
B	Магадлалтай	Энэ ажлын байранд, эсвэл компанийн хэмжээнд өмнө нь гарч байсан бөгөөд энэ талбар дээр хэзээ нэг цагт гарах магадлалтай гэж үнэлсэн, өөр олон компаниудад хэд хэдэн удаа гарч байсан	51-70%
C	Боломжтой	Хэзээ нэгэн цагт энэ ажлын байран дээр эсвэл компанид гарах боломжтой, бусад компаниудад гарч байсан	26-50%
D	Магадлал багатай	Аюулын үр дагавар энэ ажлын байранд эсвэл компанид гарах магадлал бага	11-25%
E	Магадлал маш багатай	Аюулын үр дагавар энэ ажлын байранд эсвэл компанид хэзээ нэгэн цагт гарах магадлал/боломж практикт байхгүй	0-10%

ЭРСДЭЛИЙН ОНОО	ҮЛДЭГДЭЛ ЭРСДЭЛИЙН ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ
Extreme	• Эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай • Үлдэгдэл эрсдэлийг Арилгах, Орлуулах болон Инженерчлэлийн хяналт ашиглан эрсдэлийг зохих түвшинд бууруулах яаралтай арга хэмжээ шаардлагатай, захиргааны хяналт ашиглах боломжгүй. • Хариуцсан этгээд хяналтыг баталгаажуулж, гарын үсэг зурах ёстой
High	• Эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээ шаардлагатай. • Үлдэгдэл эрсдэлийг хатуу болон зөөлөн хяналт хослуулан ашиглаж, зохих түвшинд хүргэнэ. • Хариуцсан этгээд хяналтыг баталгаажуулж, гарын үсэг зурах ёстой.
Medium	• Засаж залруулах арга хэмжээ тодорхойлох, эсвэл эрсдэлийг бууруулах байнгын хяналт/шалгалтын процессыг хэрэгжүүлэх шаардлагатай. • Үлдэгдэл эрсдэлийг хяналтын шатлалын аль ч түвшний хяналт ашиглан зохих түвшин хүртэл хянана.
Low	• Залруулах арга хэмжээг шаардлагатай тохиолдолд хэрэглэнэ. • Хүлээн зөвшөөрч болох түвшний эрсдэл. • Үлдэгдэл эрсдэлд цаашид хяналт ашиглах шаардлагагүй.

АЛХАМ 2. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ, ХЯНАЛТ
Эрсдэлийн үнэлгээний аргачлал: Энэхүү эрсдэлийн үнэлгээг олон улсын стандарт 'ISO 31000 : 2009 – Эрсдэлийн Удирдлагын Үндсэн Зарчмуудын дагуу гүйцэтгэнэ. Анхны эрсдэлийг ашиглагдаж байгаа / хүчин төгөлдөр хяналтын хүрээнд тооцоолно. Үлдэгдэл эрсдэлийг ашиглагдаж байгаа / хүчин төгөлдөр хяналт болон шинэ хяналтын хүрээнд тооцоолно. Аливаа шинэ хяналт шаардлагагүй тохиолдолд, Анхны Эрсдэл = Үлдэгдэл Эрсдэл байна. Үлдэгдэл эрсдэлийн оноо зөвшөөрөгдөх хэмжээнд байна уу?

